



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/95

Жаргалтхаан сум

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх
хаврын дархлаажуулалтын ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 59 дугаар зүйлийн 59.1, 59.1.11, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2026 оны А/59 дугаар тушаал, Аймгийн засаг даргын 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/150 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад сумын нийт үхэр, гахайг хамруулах ажлыг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэл нийт 27 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулсугай.

2. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг тогтоосон хугацаанд шуурхай, чанартай хийж гүйцэтгэхийг гэрээт мал эмнэлгийн нэгжүүдийн захирал, малын эмч нарт үүрэг болгосугай.


3. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг малчид, мал бүхий иргэдэд зарлан мэдээлж, зохих бэлтгэлийг хангуулан хамтран зохион байгуулахыг багийн Засаг дарга нарт, товлосон хугацаанд тарилгад хамрагдах малаа бэлэн байлгаж, бүрэн хамруулах, тарилга хийх хашаа хороо бэлтгэн малын эмчийн аюулгүй байдлыг ханган ажиллахыг малчид, мал бүхий иргэдэд даалгасугай.

4. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардлагатай тарилгыг татан авч, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган тарилгын явц, гүйцэтгэлд хяналт тавьж, тарилгын дүнг нэгтгэн танилцуулж, тайланг аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлж ажиллахыг Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч С.Жавзандуламд үүрэг болгосугай.

2.

5.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга С.Мөнхдэлгэрт үүрэг болгосугай.

ДАРГА



С.ГАНБАТ